

**Татварын өр төлбөртэй холбоотойгоор бизнес эрхлэгчдэд тулгарч буй
хүндрэл, нөхцөл байдлын санал асуулгын товч үр дүн
2022 оны 4 сарын 26**

Татварын өр төлбөртэй холбогдуулан холбогдох төрийн байгууллагаас аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн дансыг битүүмжилж (хааж), шүүхэд шилжүүлж байгаатай холбогдуулан үүсээд буй нөхцөл байдлыг төр хувийн хэвшил хамтран хэрхэн оновчтой шийдвэрлэх гарц шийдэл, бизнес эрхлэгчдэд шаардагдах дэмжлэгийг тодруулах зорилгоор МҮХАҮТ-аас энэхүү асуулгыг 2022 оны 4 сарын 23-25 өдрүүдэд явуулсан. Санал асуулгад боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, барилга, үйлчилгээ болон бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг нийт 133 аж ахуйн нэгж оролцсон. Энэхүү товч үр дүнгийн тайланд асуулгад оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн асуулгын үр дүнг нэгтгэн тайлагнасан бөгөөд МҮХАҮТ-ын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гол үр дүн:

- Санал асуулгад оролцсон нийт аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 65.4% нь татварын өр, татвар төлөх, данс битүүмжлэх, цаашид шүүхэд шилжүүлэх талаар холбогдох төрийн байгууллагаас мэдэгдэх хуудас хүлээн авсан бол тээвэр, уул уурхай олборлох үйлдвэрлэл, барилга, худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн 70% болон түүнээс дээш хувь нь данс битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан.
- Татварын өр, төлбөр үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн тухайд цар тахлын дараалсан хөл хорио хязгаарлалтууд (62%), хил боомтын удаашрал хүндрэлтэй холбогдуулан тээврийн нөхцөл муудсан (57%) нь хамгийн их нөлөөтэй байна. Мөн татвар, төлбөртэй холбогдох зардал (НДШ, НӨАТ, газрын төлбөр, түрээсийн төлбөр г.м), худалдан авагчийн эрэлт буурсан, төрийн бодлогын уялдаа холбоогүй ойлгомжгүй байдал, хүнд суртал голлох нөлөөтэй байна гэжээ.
- Цаашид татварын өр төлбөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг болох тухайд санал асуулгад оролцсон татварын өр төлбөртэй аж ахуйн нэгжүүдийн 62.1% нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, 24.1% нь компаниудын үйл ажиллагаа хэвийн явагдах хүртэл татвар төлөх хугацааг сунгах, 11.5% нь татварыг тодорхой хуваариар хувааж төлөх хуваарь гарган төлөх боломж олгох зэргийг нэрлэсэн байна.


Мөн бусад шаардагдах дэмжлэгийг нээлттэй асуулгаар тодруулахад: Цар тахлын дараах бизнесийн үйл ажиллагаа сэргэх эхлэл тавигдаж буй энэ үед төрийн зүгээс аж ахуйн нэгжүүдийг дэмжих урт хугацааны бодлого хэрэгжүүлэх, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтворжиход дэмжлэг үзүүлэх, татварын өрийг тэглэх, ажлын байрыг хадгалж, цалинг тасалдуулалгүй өгч буй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, АМНАТ-ыг эргэж харах, хөнгөлөлттэй зээл, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хүртээмжтэй болгох зэрэг арга хэмжээг төрийн зүгээс авах зайлшгүй шаардлагатай байна гэж үзжээ.

Асуулгын үр дүн

Нөхцөл байдал, нөлөөлсөн хүчин зүйлс

Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн 65.4% нь холбогдох төрийн байгууллагаас татварын өр, татвар төлөх, данс битүүмжлэх, цаашид шүүхэд шилжүүлэх талаар мэдэгдэх хуудас урьдчилан авсан байна. Мэдэгдэх хуудас авсан бизнес эрхлэгчдийг бизнесийн салбараар нь ангилан харвал тээвэр, уул уурхай олборлох үйлдвэрлэл, барилга, худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн 70% ба түүнээс дээш хувь нь татварын өр төлбөрийн асуудлаар компанийн данс хаах, цаашилбал шүүхэд шилжүүлэх талаар мэдэгдэх хуудас хүлээн авч илүү хүндрэлтэй нөхцөл байдалд ороод байна. (Зураг 1)

Зураг 1. Татварын өр төлбөрийн мэдэгдэх хуудас авсан байдал, салбараар



Асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдээс татварын өр, төлбөр үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлийн талаар тодруулахад 62% нь цар тахлын дараалсан хөл хорио хязгаарлалтууд, 57% нь хил боомтын удаашрал хүндрэлтэй холбогдуулан тээврийн нөхцөл муудан түүхий эд, бараа материалын үнийн өсөлт хамгийн их нөлөөтэй байсан байна. Мөн 18% нь татвар, төлбөртэй холбогдох зардал (НДШ, НӨАТ, газрын төлбөр, түрээсийн төлбөр г.м), 14% нь худалдан авагчийн эрэлт буурсан, 13% нь төрийн бодлогын уялдаа холбоогүй ойлгомжгүй байдал хүнд суртал, 11% нь ажиллах хүчний хомсдол, 8% нь гадаад валютын ханшийн хомсдол, өсөлт голлох нөлөөтэй байна гэжээ. (Зураг 2).

Зураг 2. Татварын өр төлбөр үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлс



Шаардагдах дэмжлэг

Санал асуулгад оролцсон татварын өр төлбөртэй аж ахуйн нэгжүүдийн 62.1% нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, 24.1% нь компаниудын үйл ажиллагаа хэвийн явагдах хүртэл татвар төлөх хугацааг сунгах, 11.5% нь татварыг тодорхой хуваариар хувааж төлөх хуваарь гарган төлөх боломж олгох зэрэг арга хэмжээг төрийн зүгээс авах зайлшгүй шаардлагатай байна гэж үзжээ. (Зураг 3)

Үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл барилга, боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарын бизнес эрхлэгчид төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нэн шаардлагатай байгаа бол уул уурхайн, олборлолт, хөдөө аж ахуйн болон худалдааны салбарт үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд татвар төлөх хугацааг хойшлуулах хэрэгтэй байна.

Зураг 3. Төрийн зүгээс шаардагдах дэмжлэгүүд



Бусад шаардагдах дэмжлэгийг нээлттэй асуулгаар тодруулахад дараах гол саналуудыг ирүүлсэн. Үүнд:

- Ковид 19 цар тахлын нөлөөгөөр зогсонги байдалд орсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа сэргэх эхлэл тавигдаж буй энэ үед төрийн зүгээс аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлэх, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтворжиход дэмжлэг үзүүлэх;
- НӨАТ-ын зөрүүг тухайн жилээр биш тухайн гэрээний хугацаатай уялдуулж нэхэмжлэх;
- Цар тахал, давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх;
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг түр зуурын бус, нийтлэг хувь хэмжээг бууруулах замаар зохион байгуулах, татвар төлөх хугацааг уян хатан болгох;
- Цар тахлын онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэж, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд нэг удаа татварын өрийг тэглэх, үйл ажиллагаа хэвийн болсон үеэс эхлэн татвар, НДШ-ийг төлөх;
- Сүүлийн 3 жил X тайлан гаргасан компаниудыг татан буулгаж, их цэвэрлэгээ хийх;
- Шинээр эхэлж буй жижиг дунд бизнесийг тогтвортой байлгах үүднээс эхний 1 жил татвараас хөнгөлөх, чөлөөлөх;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) гэрээний үнээс бус жишиг үнээр тооцож байгаа нь гэрээний үнэтэй харьцуулахад 200-350 хувиар тооцогдож ашигтай ажиллах боломжгүй болсон тул энэ татварын асуудлыг эргэн харах, тооцоо судалгаатай шийдвэр гаргах;

- Ажлын байрыг хадгалж, цалинг тасалдуулалгүй өгч буй ААН-үүдэд НӨАТ-ын хөнгөлөлт, буцаан олголт зэргээр татварын өр төлбөр дээр болон бусад дэмжлэг үзүүлэх;
- Тээвэр, хил, гаалийн асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх;
- Хөнгөлөлттэй зээл, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хүртээмжтэй бодитой шийдвэрлэх;
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.1-т заасан дэмжлэгийг үзүүлэх тал дээр бодит бодлогын зохицуулалт хийх;
- Компанийн дансыг битүүмжлэхээсээ өмнө заавал утсаар мэдэгдэх, татварын албаны нэгдсэн системийг алдааны магадлалыг бууруулах, аж ахуйн нэгжийн дансыг шууд хаалгүй тохиролцон график гаргах, данс хаах тухай мэдээллийг цаг тухайд нь өгөх;
- Улирлын чанартай ажилладаг жижиг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих, татварын төлөх хугацааг хойшлуулж хуваарийн дагуу төлөлт хийх боломж олгох;
- Барилгын салбарын аж ахуйн нэгжүүдэд зээл, бусад эх үүсвэрээр тусламж дэмжлэг үзүүлэх, ингэснээр салбарын мөнгөн урсгалыг нэмэгдүүлж салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэгч компаниудад дэмжлэг болох.
- Урлаг соёлын үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих, санхүү, зээлийн хөнгөлөлттэй төсөл хөтөлбөрт хамруулах, дэмжих;

--0--